

ЭМГЭНЭЛ ЛХАМСҮРЭНГИЙН ЖАМСРАН (1929-2008)



Монгол Улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн, Түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Лхамсүрэнгийн Жамсран 2008 оны 10 дугаар сарын 7-ны өдөр өвчний учир таалал төгсөв.

1929 онд Дорнод аймгийн Хонгор /одоогийн Сүхбаатар аймгийн Халзан/ сумын нутаг Чуваан шанд гэдэг газар малчин ард Хэрээд овогт Лхамсүрэнгийн хоёрдугаар хүү болон төржээ. 1949 онд Хонгор, Халзан сумдын бага, дунд

сургуулийг, 1953 онд МУИС-ийг түүхийн багшийн мэргэжлээр суралцан төгсчээ.

Улсын Багшийн Дээд Сургууль, МУИС-д түүхийн багш, тэнхимийн эрхлэгчээр ажиллаж байгаад 1957-1962 онд БНХАУ-ын Бээжин Их Сургуулийн аспирантурт суралцаж, “Вань Ли хааны байлдааны гавъяаны тэмдэглэл” хэмээх ХҮИ зууны хятад сурвалж бичгийг судалж, Монголын түүхэнд холбогдох хэсгийг орчуулж, судалгааны тайлбар, удиртгалын хамт бичиж, түүхийн ухааны дэд эрдэмтэн, 1997 онд “Монголын тусгаар тогтнолын сэргэлт” гэдэг зохиолоор Түүхийн шинжлэх ухааны докторын зэргийг амжилттай хамгаалсан манай улсын нэртэй түүхч, хятад судлаач, монголын шилдэг сэхээтний нэг байлаа.

1962-1968 онд Намын дээд сургуульд багш, декан, 1968-1980 онд ШУА-ийн Дорно Дахины хүрээлэнгийн хятад судлалын хэлтэст эрдэм шинжилгээний ажилтан, тасгийн эрхлэгч, 1982-1988 онд Улаанбаатар хотын Нийтийн аж ахуй үйлчилгээний техник мэргэжлийн сургуульд нийгэм судлалын багш, 1988-2006 он хүртэл ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнд эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, зөвлөхөөр ажиллаж байлаа. Тэрбээр Монгол Улсын үе үеийн түүхч, эрдэмтэн, судлаач, багш нарыг бэлтгэхэд жинтэй хувь нэмэр оруулжээ.

Л.Жамсран нь 30 орчим ном, зохиол, 200 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл туурвисан, Монголд төдийгүй хилийн чанадад нэр алдар нь түгсэн томоохон түүхч эрдэмтэн байлаа.

Тэрбээр “БНМАУ-ын түүх”, “Цагаагчин гахай жилийн хувьсгал”, “Монголын төрийн тусгаар тогтнолын сэргэлт”, “Монголын түүхийн бага нэвтэрхий толь” I-Үү боть, “Дарьганга”, “Манай эх орны түүхэн

“Соёл эрдэнэ”, “Монголын түүхийн дээж бичиг” И-Үү дэвтэр, “Монголын түүх судлалын өгүүллүүд” зэрэг нэгэн сэдэвт зохиолууд хэвлүүлснээс гадна, “Монгол улсын түүх” таван боть зохиол, “Хятад дахь монголчууд”, “Өвөр монголын өөртөө засах орон”, “Монгол улсын угсаатны зүй” III боть, “Монгол цэргийн уламжлал” зэрэг томоохон хамтын бүтээлд зохиогчоор оролцжээ.

Түүний бүтээл туурвилууд орос, хятад, япон, солонгос зэрэг гадаадын олон хэлээр хэвлэгдэж дэлхийн монгол судлал, Монгол Улсын болон угсаатны түүх, гадаад бодлогын уламжлалыг дэлхий дахинаа сурталчилан таниулахад жинтэй хувь нэмэр оруулжээ.

Л.Жамсрангийн хөдөлмөр бүтээлийг төр засаг өндөр үнэлж Монгол Улсын Шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол, Алтан гадас одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, Ардын хувьсгалын ойн медалиудаар шагнажээ.

Талийгаачийн уужуу тайван сэтгэл, талбиу ухаан, нөр хичээнгүй, хөдөлмөрч, тэвчээртэй эрхэм зан чанар, гэгээн дүр бидний сэтгэлд хоногшин үлдэх болно.

**Н. Энхбаяр, С.Баяр, Д.Оюунхорол, Ч.Улаан, Р.Буд,
 Ё.Отгонбаяр, Г.Мөнхбаяр, Т.Билэгт, С.Төмөр-Очир,
 Б.Чадраа, Б.Энхтүвшин, Ж.Болдбаатар, Л.Хайсандай,
 Ч.Дашдаваа, Ч.Далай, Д.Цэрэнсодном,
 ШУА-ийн Олон Улс Судлалын хүрээлэн**